



МОНГОЛ УЛС  
БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2023 оны 08 сарын 28 өдөр

Дугаар А/460

Номгон

Г Баянхонгор аймгийн өвөлжилт, хаваржилтын  
бэлтгэл ажлыг хангах, удирдан зохион байгуулах  
ажлын хэсгийг томилох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1.1, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.1 дэх заалт, Монгол Улсын Засгийн газрын 2023 оны "Хөдөө аж ахуйн салбарын 2023-2024 оны өвөлжилт, хаваржилтын бэлтгэл хангах зарим арга хэмжээний тухай" 279 дугаар тогтоол, Монгол Улсын Ерөнхий сайдын 2023 оны "Хөдөө аж ахуйн салбарын 2023-2024 оны өвөлжилт, хаваржилтын бэлтгэл хангах ажлыг эрчимжүүлэх тухай" 03 дугаар албан даалгавар, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалаар батлагдсан "Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам"-ын 2 дугаар зүйлийн 2.1.1 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:


1.Тус аймагт хийгдсэн гамшгийн эрсдэлийн ерөнхий үнэлгээ, цаг агаарын урьдчилсан төлөвөөр өвөлжилт, хаваржилт хүндрэх эрсдэл өндөр байгаа тул төвлөрсөн суурин газар болон хүнс, хөдөө аж ахуйн салбарын 2023-2024 оны өвөлжилт, хаваржилтын бэлтгэл ажлыг хангах төлөвлөгөө гарган, хэрэгжилтийг хангуулах, түүнд хяналт тавих аймгийн Онцгой комиссын Шуурхай ажлын хэсгийг нэгдүгээр, удирдамжийг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2.Аймгийн хэмжээнд өвөлжилт, хаваржилтын бэлтгэл хангах үйл ажиллагааг чиглүүлж, өвөлжилтийн бэлтгэл хангах үйл ажиллагааны төлөвлөгөө, аймгийн Онцгой комиссын даргын 2023 оны 01 дүгээр албан даалгаврын хэрэгжилтийг хангаж, авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тайланг аймгийн Онцгой комиссын хуралд танилцуулж, үр дүнг тооцож ажиллахыг шуурхай ажлын хэсгийн ахлагчид даалгасугай.

3.Өвөлжилтийн бэлтгэл ажлыг хангуулах, хяналт шалгалтын үйл ажиллагаанд шаардагдах зардлыг тухай бүрд нь шийдвэрлэж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга (Д.Энхжаргал), Санхүү, төрийн сангийн хэлтэс (С.Байгалмаа)-т тус тус зөвшөөрсүгэй.

4.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Онцгой шуурхай ажлын хэсгийн ахлагч(Б.Батсуурь)-д даалгасугай.

ДАРГА



Д.МӨНХСАЙХАН

642311179

Аймгийн Засаг даргын 2023 оны 08 дугаар сарын 28-ны өдрийн А/460 дугаар захирамжийн 1 дүгээр хавсралт

АЙМГИЙН ОНЦГОЙ КОМИССЫН  
ШУУРХАЙ АЖЛЫН ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН

Шуурхай ахлагч:	ажлын хэсгийн	
Гишүүд:	1. Б.Батсуурь	Аймгийн Засаг даргын орлогч;
	2. Ж.Алтангэрэл	Онцгой комиссын орлогч дарга, хурандаа;
	3. С.Байгалмаа	Аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга;
	4. Т.Хишигбаатар	Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга;
	5. Д.Сарангарав	Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль эрх зүйн хэлтсийн дарга;
	6. У.Балжинням	Хүнс, хөдөө аж ахуйн газрын дарга;
	7. Л.Оюун-Эрдэнэ	Мал эмнэлгийн газрын дарга;
	8. Н.Энхжаргал	Эрүүл мэндийн газрын дарга
	Ж.Алтанцэцэг	Боловсрол, шинжлэх ухааны газрын дарга
	Н.Мэндбаяр	Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын дарга
Нарийн бичиг:	8. Г.Баярсайхан	Онцгой байдлын газрын Гамшгаас хамгаалах төлөвлөлт, бэлэн байдал хариуцсан ахлах мэргэжилтэн, Гамшгаас хамгаалах улсын хяналтын байцаагч, хошууч;
	9. Б.Цэрэнханд	Хүнс, хөдөө аж ахуйн газрын Захиргаа, аж ахуйн албаны дарга;
Жолооч:		Онцгой байдлын газар болон Хүнс, хөдөө аж ахуйн газраас харилцан тохиролцсоны үндсэн дээр жолооч, авто тээврийн хэрэгслийг шийдвэрлэнэ.

-----oO-----

Аймгийн Засаг даргын 2023 оны 08 дугаар сарын  
28-ны өдрийн 7460 дугаар захирамжийн  
2 дугаар хавсралт

**АЙМГИЙН ОНЦГОЙ КОМИССЫН ШУУРХАЙ  
АЖЛЫН ХЭСГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ  
УДИРДАМЖ**

**Нэг. Зорилго**

Тус аймагт хийгдсэн гамшгийн эрсдэлийн ерөнхий үнэлгээ, цаг агаарын урьдчилсан төлөвөөр өвөлжилт, хаваржилт хүндрэх эрсдэл өндөр байгаа тул төвлөрсөн суурин газар болон хүнс, хөдөө аж ахуйн салбарын 2023-2024 оны өвөлжилт, хаваржилтын бэлтгэл ажлыг хангуулах, хяналт тавих, мэргэжлийн удирдлага, зохицуулалтаар хангах.

**Хоёр. Хугацаа, хамрах хүрээ**

2023 оны 08 дугаар сарын 30-ны өдрөөс 2023 оны 11 дүгээр сарын 30-ны өдрийг хүртэл, нийт 3 сарын хугацаанд тус аймгийн 20 сум болон холбогдох байгууллагуудыг хамруулан зохион байгуулна.

**Гурав. Хяналт, шалгалтын үйл ажиллагааны чиглэл:**

**3.1.Төв, суурин газрын өвөлжилтийн бэлтгэл ажлын талаар:**

3.1.1.Аймгийн Засаг дарга, Онцгой комиссын даргын 2023 оны 08 дугаар сарын 28-ны өдрийн 01 дүгээр албан даалгаврын хэрэгжилтийг хангах нэгдсэн болон салбар тус бүрээр нарийвчилсан төлөвлөгөө гаргаж, хэрэгжилтийг хангасан эсэх(0-10 оноо);

3.1.2.Сумдын Онцгой комиссын үйл ажиллагаа, бэлэн байдлыг шалгах, сумдын Засаг даргын нөөц хөрөнгийн захиран зарцуулалт (0-10 оноо);

3.1.3.Улс, орон нутгийн хөрөнгө оруулалтаар хийгдэж буй барилга, байгууламж, авто зам гүүр зэрэг дэд бүтцүүдийг шинээр барих болон арчлалт, засварын ажлуудыг хугацаанд нь чанартай гүйцэтгүүлж, ашиглалтад оруулах, он дамжих барилгуудыг хамгаалалтын горимд шилжүүлсэн байдал (0-10 оноо);

3.1.4.Нутгийн захиргааны байгууллага, Эрүүл мэнд, Шатахуун түгээх станц, Дулаан үйлдвэрлэгч аж ахуй нэгжүүдийн цэвэр бохир ус, дулааны шугам сүлжээний засвар үйлчилгээ, түлээ, нүүрсний татан авалт, нөөц цахилгаан үүсгүүрийн бэлэн байдал (0-10 оноо);

3.1.5.Төв суурин газрын цахилгаан эрчим хүчний засвар үйлчилгээ, найдвартай ажиллагаа, аюулгүй байдал (0-10 оноо);

## 2.

3.1.6. Аймаг, сумын эрүүл мэндийн байгууллагад шаардлагатай эм, эмнэлгийн хэрэгслийн нөөц бүрдүүлэн, яаралтай тусламжийн автомашин, багаж хэрэгслийн бэлэн байдлыг хангасан эсэх(0-10 оноо).

### 3.2. Хүнс, хөдөө аж ахуйн салбарын өвөлжилтийн бэлтгэл ажлын талаар:

3.2.1. Хөдөө аж ахуйн салбарын өвөлжилт, хаваржилтын бэлтгэл хангах ажлын нэгдсэн төлөвлөгөө гарган, холбогдох мэргэжлийн байгууллагатай хамтран чанар, үр дүнтэй зохион байгуулж байгаа эсэх(0-10 оноо);

3.2.2. Малын хашаа хороо, саравч засварлах, шинээр барих, хүрэлцээг нэмэгдүүлэх, бууц хэвтрийг хатаах, өвөлжилт, хаваржилтын нөхцөл байдал хүндэрсэн үед хэрэглэх өвс, тэжээл, гар тэжээл, түлээ түлшээ нөөцлөх, хоол хүнс, хувцас хэрэглэл, эм хэрэгсэл зэргийг базааж өвөлжилтийн бэлтгэлийг малчдын түшинд сайтар хангахыг уриалж, энэ чиглэлээр нэгдсэн арга хэмжээ зохион байгуулж байгаа эсэх(0-10 оноо);

3.2.3. Өвөлжилт, хаваржилтын бэлтгэл ажлын талаарх мэдээ, мэдээллийг үнэн зөв, бодитоор гаргаж, мэргэжлийн байгууллагуудыг тухай бүр мэдээллээр хангасан байдал(0-10 оноо);

3.2.4. Хадлан тэжээл бэлтгэх техник, тоног төхөөрөмжийн хангалтыг сайжруулах чиглэлээр шаардлагатай арга хэмжээ авсан эсэх(0-10 оноо);

3.2.5. Зарим шаардлагатай хадлангийн талбайг өнжөөх, сэлгэх, хадлан бэлтгэх гэрээ хэлэлцээ хийж, зохицуулалт хийсэн байдал(0-10 оноо);

3.2.6. Сумын аюулгүйн нөөцөд бүрдүүлэх өвс, тэжээлийг холбогдох газартай гэрээ байгуулан 2023 оны 11 дүгээр сарын 15-ны өдрийн дотор татан төвлөрүүлж, байршуулсан байх(0-10 оноо);

3.2.7. Улсын тусгай хамгаалалттай газар, улсын тусгай хэрэгцээний аймаг дундын отрын бүс нутгийг ашиглах гэрээг байгуулах талаар саналаа холбогдох дээд шатны газарт хугацаанд нь явуулж шийдвэрлүүлсэн эсэх(0-10 оноо);

3.2.8. Бусад аймгийн нутаг дэвсгэрт отор нүүдэл хийж, өвөлжиж, хаваржих малчдад шаардлагатай үед эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг шуурхай үзүүлэх, сумдын эрүүл мэндийн төв болон багийн эмч нарын эргэлтийг сайжруулах ажил, арга хэмжээг зохион байгуулахаар төлөвлөсөн эсэх(0-10 оноо).

### 3.3. Мал эмнэлгийн салбарын өвөлжилтийн бэлтгэл ажлын талаар:

3.3.1. Отроор нүүдэллэж байгаа малчин өрхийг тухайн орон нутгийн захиргааны байгууллага болон хүн, мал эмнэлгийн байгууллагад бүртгүүлж, холбогдох мэргэжлийн байгууллагын тусламж үйлчилгээг тухай бүр шуурхай авах нөхцөл боломжийг бүрдүүлсэн байдал(0-10 оноо);

3.

3.3.2.Мал, амьтны гоц халдварт өвчин болон паразитгах өвчнөөс урьдчилан сэргийлэх зорилгоор малын хашаа, байрны ариутгал, халдваргүйжүүлэлтийн арга хэмжээг технологит хугацаанд нь чанартай зохион байгуулсан эсэх(0-10 оноо);

3.3.3.Мал, амьтны гоц халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх ажлыг эрчимжүүлэх, хорио цээр, хязгаарлалтын дэглэмийн хэрэгжилтийг шалгах, мал эмнэлгийн нэгжүүдийн бэлтгэл, бэлэн байдлыг хангуулах (0-10 оноо);

3.3.4.Сумынхаа нийт мал сүрэгт үзлэг ангилалт явуулж, тарга хүч муутай, хөгшин, үржилд тэнцэхгүй малыг зах зээлд борлуулах, өвөлжих малын тоог цөөлөх улмаар иргэдийн хүнсний хэрэгцээт махны нөөцийг нэмэгдүүлсэн эсэх(0-10 оноо);

3.3.5.Малын тоо толгойн албан татварын тухай хуулийн хэрэгжилтийг хангуулж, орлого бүрдүүлэлтийг ил тод болгох, орлогын эх үүсвэрийг хууль тогтоомжид заасны дагуу эрэмбэлэн зарцуулах, хяналт тавьж байгаа эсэх(0-10 оноо);

3.3.6.Сумын нийт бэлчээрийн 10-аас доошгүй хувийг байгаль, цаг агаарын хүндрэлтэй нөхцөл байдлын үед ашиглах нөөц бэлчээрээр авсан эсэх(0-10 оноо);

3.3.7.Сумын томилгоот мэргэжлийн ангийн бүрэлдэхүүний бэлтгэл, бэлэн байдлыг хангуулах, дайчлагдан ажиллах хүч хэрэгслийг тодотгож, холбогдох үүрэг чиглэлээр хангасан байдал(0-10 оноо);

Сумын Онцгой комиссын хурлыг зохион байгуулж, өвөлжилтийн бэлтгэл ажилд үнэлгээ дүгнэлт өгч, санал хүсэлтийг албан бичгээр хүлээн авах.

Үнэлгээний хуудас: Загвар.

Сумдын нэр: .....

д/д	Хяналтын үйл ажиллагааны чиглэл	Оноо	Тайлбар
1			
2			
3			
10			
-	Нийт дүн	0-100	

**Дөрөв.Дүгнэлт**

Тухайн сумын өвөлжилтийн бэлтгэл ажлын нэгдсэн үнэлгээ, дүгнэлтийг аймгийн Онцгой комиссын хуралд танилцуулж, өвөлжилтийн бэлтгэл ажлын хэрэгжилт хангалтгүй үнэлгээ авсан сум, орон нутгийн болон байгууллага, аж ахуйн нэгжийн дарга, захиралд, иргэдэд холбогдох хууль тогтоомжид заасны дагуу хариуцлага тооцуулах.

\_\_\_\_\_оОо\_\_\_\_\_